



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



info@mta.gov.mn

+976-11-314155, 318793

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, С.Данзангийн гудамж 4-А

Агуулга

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН	2
Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	2
1.1 Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол, шийдвэр Ерөнхий сайдын захирамж, шийдвэрийн биелэлт	3
1.2 “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хэрэгжилт.....	3
1.3 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	3
1.4. Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг, даалгаврын биелэлт	4
1.5. Улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилт	5
Хоёр. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ.....	5
2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчаас агентлагийн ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	6
2.2 Агентлагийн тухайн оны төсвийн гүйцэтгэл.....	6
2.3 Агентлагийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:	7
2.4 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагааны хэрэгжилт 8	
2.5 Аудит, хяналт-шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлт	9
2.6 Шилэн дансны хөтлөлт.....	15
Гурав. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээний тайлан.....	15
Дөрөв. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	16
4.1 Агентлагийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт	16
4.2 Хэрэглэгчийн үнэлгээ	16

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилт

Дээд газрын бодлого, зорилтын хүрээнд 2022 онд агентлагийн хэмжээнд хэрэгжүүлсэн зорилт, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Татварын албаны 2022 оны үндсэн чиглэл болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүд нь үр дүнд хүрсэн эсэх, татварын албаны үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн менежментийг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан удирдлагыг шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх мэдээлэл, зөвлөмжөөр хангахад чиглэгдсэн болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Татварын ерөнхий газрын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын Сангийн сайдын 2018 оны 143 дугаар тушаалаар баталсан “Сангийн яамны харьяа агентлагийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”, Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Татварын албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-аар тодорхойлсон арга зүйн хүрээнд гүйцэтгэлээ.

Хамарсан хүрээ

Агентлагийн 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, хүрсэн үр дүнг мэдээ, тайлан, судалгаа, баримт материалд тулгуурлан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээг үзүүлэлт тус бүрээр танилцуулж тайланг бэлтгэлээ.

- Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ
- Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ
- Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ҮЗҮҮЛЭЛТ		Үнэлгээнд авах оноо	Хувь	Оноо
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	10	98.29	9.83
2	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	40	98.58	39.34
3	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	5	99.49	4.97
4	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	45	95.46	42.38
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		100	96.53	96.53

Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд журам, аргачлалаар тодорхойлсон дараах 3 үзүүлэлтүүдийг авч үзлээ. Үүнд:

Д/Д	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Үнэлгээ	Оноо
1.1	Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, шийдвэр, Ерөнхий сайдын захирамж, шийдвэрийн биелэлт	97.52	1.95
1.2	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичгийн биелэлт /“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”/	98.33	1.97

1.3	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	100.0	2.00
1.4	Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг, даалгаврын биелэлт	100.0	2.00
1.5	Улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр	95.61	2.00
Үнэлгээний нийт оноо		98.29	9.83

1.1 Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол, шийдвэр Ерөнхий сайдын захирамж, шийдвэрийн биелэлт

Тайлант хугацаанд татварын албаны хэмжээнд дээд газрын 24 тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **97.52** хувиар үнэлэгдэж байна. Хяналтад авсан шийдвэрийн нэгтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. (Хавсралт-1, дэлгэрэнгүй)

Д/Д	Дээд газрын тогтоол, шийдвэр, үүрэг даалгавар	Шийдвэрийн тоо	Гүйцэтгэл	
			Хувь	Оноо
1.1.1	Ерөнхийлөгчийн зарлиг	1	90	1.80
1.1.2	Засгийн газрын тогтоол	8	97.25	1.95
1.1.3	Ерөнхий сайдын захирамж	2	100	2.00
1.1.4	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	7	97.86	1.96
1.1.5	1.Ерөнхий сайдын албан даалгавар	1	100	2.00
1.1.6	Сангийн сайдын тушаал	4	100	2.00
Нийт дүн		23	97.52	1.95

Тайлант хугацаанд нийт дээд газрын тогтоол, шийдвэр 24 ирснээс 23-т үнэлгээ хийж 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн 2021 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах үед “УИХ-ын 2020 оны 45-р тогтоол болон 2021 оны 10 дугаар тогоолын хэрэгжилтийг ханган, салбарын дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасны дагуу хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусган боловсруулах ажлыг эрчимжүүлэхийг ЗГГ-үүд болон агентлагийн дарга нарт, улсын хэмжээнд зохион байгуулж ЗГ-т танилцуулахыг СС-д бөгөөд ЭЗХСайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгав” гэсний дагуу яамнаас санал авах асуудлаар манай байгууллагад одоогоор албан бичиг, хүсэлт ирээгүй байгаа тул тайлагнаж, үнэлээгүй болно.

1.2 “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хэрэгжилт

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг баталсан. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Сангийн сайдын дангаар болон бусад яамдтай хамтран хэрэгжүүлэх татварын албаны үйл ажиллагаатай холбоотой 6 арга хэмжээ тусгагдсаныг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:

Д/д	Арга хэмжээний тоо	Үнэлгээ	
		хувь	Оноо
1	6	98.33	1.96
Нийт үнэлгээ		98.33	1.96

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг хүрээнд татварын албанаас хэрэгжүүлсэн 6 үйл ажиллагааны хэрэгжилтийг Засгийн газрын 2022 оны 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад “09 дүгээр сарын 01-ний дотор” гэж заасны дагуу 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 03/1549 дүгээр албан бичгээр Сангийн яамны ТЗУГ-т хүргүүлсэн. (Хавсралт-2)

Гүйцэтгэлийн хувь: 98.33

1.3 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Сангийн яамны хэрэгжүүлэх арга хэмжээнд татварын албаны үйл

ажиллагаатай холбоотой 7 арга хэмжээ тусгагдсаныг Татварын ерөнхий газрын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг тухай бүр ханган ажилласан ба агентлагийн хэмжээнд **100.0** хувиар үнэлэгдэж байна.

Д/д	Арга хэмжээний тоо	Үнэлгээ	
		хувь	Оноо
1	7	100	2.0
Нийт үнэлгээ		100.0	2.0

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар хэсгийн 7.3 дах заалтын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тус журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд буюу 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 03/2894 дүгээр албан бичгээр Сангийн яамны ТЗУГ-т хүргүүлсэн. (Хавсралт-3)

Гүйцэтгэлийн хувь: 100.0

“Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” тогтоолоор баталсан Сангийн яамны хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд татварын албаны үйл ажиллагаатай холбоотой 2 арга хэмжээ тусгагдсан ба хэрэгжилтийг ханган ажилласан. Хэрэгжилтийг нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд буюу 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 03/2894 дүгээр албан бичгээр Сангийн яамны ТЗУГ-т хүргүүлсэн. (Хавсралт-4)

Гүйцэтгэлийн хувь: 90.0

Мөн Монгол Их Хурлын 2021 оны 56 дугаар “Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолоор баталсан төлөвлөгөөнд Сангийн яамны хэрэгжүүлэх арга хэмжээнд татварын албаны үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээ тусгагдаагүй болно.

Гүйцэтгэлийн хувь: Үнэлээгүй

1.4. Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг, даалгаврын биелэлт

Тайлант хугацаанд Татварын албанд Сангийн сайдын 1 тушаал ирснийг бүртгэн, хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Д/д	Өгсөн үүрэг шийдвэрийн тоо	Гүйцэтгэл	
		Хувь	Оноо
1	1	100.0	3.0
Нийт үнэлгээ		100.0	3.0

2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 12 дугаар тушаал

“Монгол Улсын 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт хангуулах” тухай тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг онцгой анхаарна уу.

Хэрэгжилт: Монгол Улсын 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах, далд эдийн засгийг бууруулж татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага, татварын өр барагдуулах үйл ажиллагааг сайжруулах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, татвар төлөх тайлагнах, гадаад худалдаа хийх цаг, зардлыг бууруулах, гадаад худалдааг хөнгөвчлөх ажлын хүрээнд татварын албанаас 72 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, ажлын төлөвлөгөөний хуваарийг боловсруулж, Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулж ажилласан.

Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зохион байгуулсан ажил, хүрсэн үр дүнгийн тайланг сар бүр ЗББН-үүдээс авч нэгтгэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Хэрэгжилтийн тайланг 2022.02.16-ны өдрийн 01/320 тоот, 2022.03.10-ны өдрийн 01/551 тоот, 2022.04.08-ны өдрийн 01/798, 2022.05.10-ны өдрийн 01/1055, 2022.06.10-ны өдрийн 01/1385 тоот, 2022.07.08-ны өдрийн 01/1603 тоот, 2022.08.10-ны өдрийн 01/1751 тоот, 2022.09.09-ний өдрийн 01/1975, 2022.10.07-ны өдрийн 01/2194, 2022.11.10-ны өдрийн 01/2466 тоот албан бичгээр, 2022 оны жилийн тайланг өссөн дүнгээр гарган 2023 оны 01 сарын 10-ны өдрийн 01/62 дугаартай албан бичгээр нийт 11 удаа тайлагнаж, Сангийн яаманд хүргүүлэв. **Гүйцэтгэлийн хувь: 100.0**

2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тушаал

Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу албан татвар төлөгчийн илүү төлсөн албан татварыг буцаан олгох, уг үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бүртгэл хөтлөх, хяналт тавих харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хэрэгжилт: Тайлант хугацаанд Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу 53'291 татвар төлөгч илүү төлсөн албан татвар буцаан авах хүсэлтийг цахимаар ирүүлсэн ба хүсэлтэд хяналт тавьснаар 53'291 иргэнд 50.6 тэрбум төгрөгийн буцаан олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэн, ТУНС-д бүртгэлийг хөтөлж ажилласан.

Үнэлгээ: 100.0

2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 20 дугаар тушаал

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу албан татвар төлөгчийн илүү төлсөн албан татварыг буцаан олгох, буцаан олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бүртгэл хөтлөх, нягтлан бодох бүртгэлд тусгах, буцаан олголтын хяналтыг хэрэгжүүлэх харилцааг энэ журмаар зохицуулна.

Хэрэгжилт: ААНОАТ-ын буцаан олголтыг цахимаар хүсэлт хүлээн авах, ТУНС-ээр гүйлгээг Төрийн санд шилжүүлэх нэвтрүүлэлтийг бүрэн хийснээр нийт 2'779 татвар төлөгчийн 41.8 тэрбум төгрөгийн буцаан олголтыг баталгаажуулан, олгосон. Мөн бусад татварын өрд 776 татвар төлөгчийн 7.7 тэрбум төгрөгийг суутган тооцсон.

Үнэлгээ: 100.0

1.5. Улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилт

Татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, татварын албаны чадавхийг бэхжүүлэх, татвар төлөгчийн хууль тогтоомж мөрдөлтийг сайжруулах талаар Монгол улсын Сангийн яам, Татварын ерөнхий газар, Олон улсын валютын сангийн төсвийн асуудал эрхлэх газар, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /ЭЗХАХБ/, Нэгдсэн үндэсний байгууллага, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагууд хамтран ажиллахаар баталсан санамж бичигт тусгагдан 2022 онд татварын албанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг нэгтгэн гаргалаа.

Татварын албаны хэмжээнд 2022 онд улсын төсөв, гадаадын зээл тусламжаар 3 төсөл, 1 хөтөлбөр хэрэгжиж байна. Дээрх төсөл, хөтөлбөрт татварын албанаас 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа хэрэгжилтэд ХШҮ хийхэд 95.61 оноогоор “Маш сайн” гэж үнэлэгдэж байна. Төсөл, хөтөлбөрт хийсэн үнэлгээг танилцуулбал дараахь байдалтай байна.

Д/д	Төсөл, хөтөлбөрийн нэр	Ажлын тоо	Оноо	Үнэлгээ
1	Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх	7	94.16	Маш сайн
2	Татварын шинэ хуулийн хэрэгжилтийг хангах татварын албаны чадавхийг бэхжүүлэх	13	95.16	Маш сайн
3	Татварын бодлого, татвар төлөгчдийн хууль тогтоомж мөрдөлтийг сайжруулах төслийн үнэлгээ	15	98.12	Маш сайн
4	Хил хязгааргүй татварын байцаагч хөтөлбөрийн үнэлгээ	7	95.00	Маш сайн
Дундаж үнэлгээ		42	95.61	Маш сайн

Нийт 4 төсөл, хөтөлбөрийн хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлж байгаагаас бүх хөтөлбөрийн хэрэгжилт “Маш сайн” үнэлэгдсэн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг (Хавсралт-5) хавсаргав.

Үнэлгээ: 95.61

Хоёр. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ

Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээнд 6 үзүүлэлтүүдийг авч үзлээ. Үүнд:

Д/д	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Үнэлгээ	Оноо
-----	--	---------	------

2.1	Төсвийн ерөнхийлөн захирагчаас агентлагийн ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	97.65	14.65
2.2	Агентлагийн тухайн оны төсвийн гүйцэтгэл	98.00	4.90
2.3	Агентлагийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	100.00	5.00
2.4	Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагааны хэрэгжилт	98.71	4.94
2.5	Аудит, хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлт	97.14	4.86
2.6	Шилэн дансны хөтлөлт	100.00	5.00
Үнэлгээний нийт оноо		98.58	39.34

2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчаас агентлагийн ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 04 дүгээр хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний загварын хүрээнд “ТЕГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Төлөвлөгөөнд “ТАТВАРЫН БОЛОВСРОЛЫН ЖИЛ” зорилтын хүрээнд 14, “ХУУЛЬ ТОГТООМЖ, ЧИГ ҮҮРЭГ”-ийн зорилтын хүрээнд 37, нийт 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг тусгасан. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд харьцуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд гүйцэтгэл 97.65 хувь байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсралтаар хүргүүлэв. /хавсралт-6/

Зорилт	Арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Нийт Үнэлгээ
Татварын боловсролын жил зорилт	14	14	-	97.14
Хууль тогтоомж, чиг үүргийн зорилт	37	35	2	97.84
Нийт	51	49	2	97.65

Гүйцэтгэлийн хувь: 97.65

2.2 Агентлагийн тухайн оны төсвийн гүйцэтгэл

Агентлагийн тухайн оны төсвийн гүйцэтгэлийн үнэлгээнд 3 үзүүлэлтүүдийг авч үзлээ. Үүнд:

2.2.1. Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Хэрэгжилт: Татварын албаны хэмжээнд 2022 онд 46,661.03 сая төгрөгийн төсвийг харьяа татварын албадуудад хуваарилан, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан. ТЕГ-ын 2022 оны нийт урсгал зардал 45,560.99 сая төгрөгийг төлөвлөснөөс улсын төсвийн санхүүжилтээр 42,550.99 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,890.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 120.0 сая төгрөгийн эх үүсвэрээс зарцуулахаар төсөвлөсөн байна.

2022 онд улсын төсвөөс 43,498.89 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 3,592.34 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 386.41 сая төгрөгийн орлогыг тус тус олж нийт 47,091.62 сая төгрөгийн төсвийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд татварын албаны албан хаагчдын цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 27,434.45; ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 3,500.69; байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,632.56, хангамж бараа материалын зардалд 823.16, норматив зардалд 0.0, эд хогшил, урсгал засварын зардалд 198.59; томилолт, зочны зардалд 92.53; бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 5,756.39, бараа үйлчилгээний бусад зардалд 162.19, бусад урсгал шилжүүлэг 1,234.12 сая төгрөг нийт 39,600.57 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Гүйцэтгэлийн хувь: 97.0

2.2.2. Өглөг, авлагын талаар:

2022 оны эхний авлагын нийт үлдэгдэл 1,470.1 сая төгрөг бүртгэгдсний 1,098.3 сая төгрөг нь Сангийн Яамнаас авах авлага байснаас 169.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,118.3 сая төгрөгөөр хорогдсон. Бусад байгууллагаас авах авлага эхний үлдэгдэл 345.2 сая төгрөг байснаас 2.7 сая

төгрөгөөр нэмэгдэж, 332.8 сая төгрөгөөр хорогдож 15.1 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага эхний үлдэгдэл 2,8 сая төгрөг байснаас 3.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 3.9 сая төгрөгөөр хорогдож 2.8 сая төгрөг, нийт 166.9 сая төгрөгийн авлагатай байна.

2022 оны эхний өглөг 680.0 сая төгрөг байснаас 35.9 сая төгрөгний өглөг нэмэгдэж, 641.7 сая төгрөгний өр барагдаж тайлант хугацааны эцэст 74.2 сая төгрөг байна. Тайлант хугацаанд байр ашиглалтын тогтмол зардлын өглөгийг Багануур, Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Өмнөговь аймгийн татварын албад нь 1.5 сая төгрөг, түлш шатахууны өглөгийг Өвөрхангай, Увс аймгийн татварын хэлтэс нь 4.8 сая төгрөг, бусад байгууллагад өгөх өглөгийг Баянгол, Багануур, Архангай, Баян-өлгий, Өвөрхангай, Өмнөговь, Увс аймгийн татварын албад нь 10.2 сая төгрөг, газрын төлбөр, бусад татварын өглөгийг Нийслэлийн татварын газар, Архангай, Хөвсгөл аймгийн татварын хэлтэс нь 1.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байсныг тайлант хугацаанд бүрэн барагдуулсан байна. ТЕГ нь бусад байгууллагад өгөх өглөгийг 218.8 сая төгрөг, Завхан, Сэлэнгэ аймгийн татварын хэлтэс нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг 1.4 сая төгрөгөөр тус тус барагдуулсан байна.

Гүйцэтгэлийн хувь: 97.0

2.2.3. Орон тоо, цалингийн сангийн талаар:

2022 онд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 35,007.93 сая төгрөг зарцуулах төсөвтэйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 30,935.14 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Гүйцэтгэлийн хувь: 100.0

Төсвийн гүйцэтгэлийн үнэлгээ: 98.0

2.3 Агентлагийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтад ТЕГ-ын 2022 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг оруулж, төсөл арга хэмжээний жагсаалтад худалдан авах ажиллагааг нэг бүрчлэн бүртгэж дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулснаас улсын төсвөөс санхүүжих дүн 5,934.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 18 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд урсгал төсвөөр 8 төсөл арга хэмжээний санхүүжилт 1,651.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Татварын албаны хөрөнгө оруулалтын төсвөөр хийх их засварын ажил

/мянган төгрөг/				
д/д	Барилга байгууламж	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэмнэлт
1	Татварын хэлтсийн конторын барилгын өргөтгөл, их засвар /Архангай аймаг, Эрдэнэбулган сум /	608,000.0	0.0	2022 оны төсвийн тодотголоор төсөвт өртөг татагдсан
2	Татварын хэлтсийн конторын барилгын өргөтгөл, их засвар /Булган аймаг, Булган сум /	637,000.0	608,016.0	28,984.0
3	Татварын хэлтсийн конторын барилгын их засвар /Баян-өлгий аймаг, Өлгий сум/	219,200.0	207,500.0	11,700.0
4	Татварын хэлтсийн барилгын дээвэр, сантехникийн их засвар /Дархан-Уул аймаг/	42,000.0	40,996.1	1,003.9
5	Татварын хэлтсийн конторын барилгын 1,5 давхарын их засвар /Улаанбаатар, Татварын Ерөнхий газар /	435,000.0	0.0	2022 оны төсвийн тодотголоор төсөвт өртөг татагдсан
6	Татварын хэлтсийн конторын барилгын сантехник, их засвар /Улаанбаатар, Нийслэлийн татварын газар/	33,400.0	0.0	2022 оны төсвийн тодотголоор төсөвт өртөг татагдсан
7	Татварын хэлтсийн барилгын дээврийн их засвар /Говьсүмбэр аймаг/	25,400.0	0.0	2022 оны төсвийн тодотголоор төсөвт өртөг татагдсан
Нийт дүн		2,000,000.0	856,512.1	41,687.9

Булган, Баянөлгий, Дархан-Уул аймгуудын татварын хэлтсийн засварын ажлыг 2022 онд цахим тендер шалгаруулах журмын дагуу зохин байгуулсан бөгөөд засварын ажил 100 хувьтай хийгдсэн. 1,101.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээ 2022 оны төсвийн тодотголоор төрийн хэмнэлтийн хуулийн дагуу буцаан татагдсан байна.

Татварын албаны хөрөнгө оруулалтын төсвөөр тоног төхөөрөмж худалдан авах ажил

/мянган төгрөг/

д/д	Барилга байгууламж	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	Хэмнэлт
1	Серверийн өрөөнд стандартын дагуу агаар чийгшүүлэгчтэй эйр кондэйшн худалдан авах, суурилуулалт	50,000.0	44,264.0	5,736.0
2	Кибер аюулгүй байдлын зөвлөмжийн татварын албаны сервер, сүлжээний төхөөрөмжийн төлвийн хяналтын систем	109,026.0	106,980.8	2,045.2
3	1800-1288 Операторын чихэвч	38,000.0	36,432.0	1,568.0
4	Кибер аюулгүй байдлын зөвлөмжийн дагуу татварын албаны хуучин системүүдийн баазын нөөцлөлт, туслах системүүдийн орчин, хөгжүүлэлтэд шаардлагатай серверийн сэлбэг хэрэгсэл	313,664.6	0.0	2022 оны төсвийн тодотголоор төсөвт өртөг татагдсан
5	Мэдээлэл технологийн инженерүүдэд үзүүлэлт сайтай зөөврийн компьютер	47,600.0	0.0	Гэрээний үүргээ биелүүлэггүй тул гэрээ цуцалсан
6	Сүлжээний хамгаалалтын төхөөрөмжийн лиценз /Fortigate 2000E 4 ширхэг/	712,500.0	0.0	2022 оны төсвийн тодотголоор төсөвт өртөг татагдсан
7	Хэвлэх тоног төхөөрөмж	100,000.0	0.0	2022 оны төсвийн тодотголоор төсөвт өртөг татагдсан
8	Татварын албадын техник тоног төхөөрөмжийн суурь, хаалт, нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах хэрэгсэл, эд зүйлс	1,629,209.4	0.0	2022 оны төсвийн тодотголоор төсөвт өртөг татагдсан
Нийт дүн		3,000,000.0	187,676.8	56,949.2

Тоног төхөөрөмж худалдан авахаар тендер шалгаруулах журмын дагуу зохин байгуулсан бөгөөд гүйцэтгэл 100 хувьтай байна. 46.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ хил хаагдсантай холбоотойгоор Саммит электроникс ХХК хугацаандаа нийлүүлж чадахгүй болсон тул цуцалсан, 2,755.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээ 2022 оны төсвийн тодотголоор төрийн хэмнэлтийн хуулийн дагуу буцаан татагдсан байна.

Татварын албаны 2022 онд урсгал төсвөөр хийх худалдан авах үйл ажиллагаа

Улсын төсвийн урсгал төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжих 934.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд урсгал төсвөөр 1 төсөл арга хэмжээг 552.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 274.6 сая төгрөгийн хэмнэлттэйгээр ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг бүрэн зохин байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Татварын албаны сүлжээнд холбогдсон 300 сумдын байцаагчдын албан байрны VPN холболтын үйлчилгээ	827,000.0	552,336.00
2	Бензин, шатах тослох материал худалдан авах	22,619.4	0.0
3	Антивирус программ	84,600.0	54,945.0
Нийт дүн		934,219.4	607,281.0

Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой 3 тендер зарлагдсанаас Татварын тайлан сүлжээнд холбогдсон 300 сумдын байцаагчдын албан байрны VPN холболтын үйлчилгээ үзүүлэх тендерт оролцсон “Юнивишн” ХХК шалгарсан оролцогч нараас ямар нэгэн гомдол маргаан үүсээгүй, Бензин, шатах тослох материал худалдан авахаас 2022 оны төсвийн тодотголоор төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 22.6 сая төгрөг буцаан татагдсан, Нийт 8 худалдан авах ажиллагаа зохион байгуулж 304.3 сая төгрөгийн төсвийн хэмнэлт хийсэн байна.

Гүйцэтгэлийн хувь: 100.0

2.4 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагааны хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралт “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт”-ийг хангах зорилгоор татварын албаны хэмжээнд төрийн албан хаагчийн нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагааны ажлын биелэлт, үнэлгээ дараах байдалтай байна. Үүнд:

Д/д	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоо тоо	Үнэлгээ	
			Хувь	Оноо
1	Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх	9	99.92	4.99

2	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	5	97.50	4.87
Нийт дүн		14	98.71	4.94

Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн **14 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийсэн. (Хавсралт-7) Гүйцэтгэлийн хувь: 98.71**

2.5 Аудит, хяналт-шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлт

Төрийн аудитын газраас Татварын ерөнхий газрын үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн аудит, СЯ-ын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 1/3726 дугаар албан бичгээр ирүүлсэн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-ний зөвлөмж, албан шаардлагын дагуу зөрчил дутагдлыг арилгасан байдлыг нэгтгэн харуулбал:

Дүгнэлт, зөвлөмж, шаардлага ирүүлсэн байгууллага	Зөвлөмж шаардлагын тоо	Зөрчил дутагдлыг арилгах талаар төлөвлөгөө гаргасан байдал	Хэрэгжүүлсэн гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ
Үндэсний Аудитын газар /санхүү/	8	-	97.50	4.88
Сангийн яамнаас 2021 оны үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-ний тайлангаар өгсөн зөвлөмж	14	-	96.79	4.84
Нийт			97.14	4.86

Үндэсний аудитын газраас хүргүүлсэн шаардлагын дагуу гүйцэтгэсэн ажлын хэрэгжилт:

ҮАГ-аас ТЕГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт гарган, 5 албан шаардлага, 3 зөвлөмж ирүүлснээс төлөвлөгөө гарган хэрэгжилтийг 2022 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 3/2155 дугаар албан бичгээр хүргүүлснээс 97.50 хувьтай хэрэгжүүлсэн.

Төрөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл	Хувь
Албан шаардлага	Төсвийн хэмнэлтийн талаар гаргасан Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022 оны 5-р сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоолын хэрэгжилт ТЕГД-ын 2022.05.18-ны өдрийн А/56 дугаар тушаалаар ТЕГ-ын харьяа нэгж, НТГ, аймаг, дүүргийн татварын хэлтсийн орон тоог шинэчлэн батлуулав. Татварын ерөнхий газрын даргын 2022.05.18-ны өдрийн Б/346-453 тушаалаар Том татвар төлөгчийн газар, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн 8 дэд даргыг албан тушаалаас нь чөлөөлсөн. Татварын албадад 2023 оны урсгал төсвийн төлөвлөлтийг хийхдээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллуулахаар 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 03/1297 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Төсвийн хэмнэлтийн тухай хууль болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэн, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулан, өмнөх зөрчлийг давтан гаргахгүй ажилласнаар 2022 онд албадын хэмжээнд 5,2 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.	100
Албан шаардлага	Нягтлан бодох бүртгэлийг иж бүрэн хөтөлж, хөрөнгийн тооллогын бүртгэл, тооцоог бодож баримтжуулан баталгаажуулах, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайланг Үндэсний	Татварын ерөнхий газрын даргын 2016 оны 12-р сарын 09-ны өдрийн А/43 тоот тушаалын дагуу эргэлтийн бус хөрөнгийг санхүүгийн программ бүртгэлтэй тулган эд хариуцагч нарыг байлцуулан тооллогыг үнэн зөв бодитой, нэг бүрчлэн нүдлэн тоолж, эд хариуцагч нарын картыг шинээр хөтлөн бүртгэсэн. 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн үндсэн хөрөнгийн тооллого	100

	аудитын газарт хүргүүлж байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.	хийж үндсэн хөрөнгийн 642.8 ширхэг хөрөнгийн 585,162,938.14 төгрөг, бараа материалын 8325 ширхэг 24,626,254.00 төгрөгийг тоолж бүртгэлжүүлсэн. Том татвар төлөгчийн газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 02-ний өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, үндсэн хөрөнгийн тооллогын ажлыг зохион байгуулах комисс томилох тухай” А/20 дугаар тушаалын дагуу тус газрын үндсэн хөрөнгийг тооллого хийж үндсэн хөрөнгийн 1142.8 ширхэг 634,303,871.2 төгрөг, бараа материалын 22,734,289.00 төгрөгийн хөрөнгийг тоолж бүртгэлжүүлсэн. Сангийн сайдын 2017 оны 12 сарын 05-ны баталсан НХМаягт БМ-9 маягтын дагуу сар бүр бараа материалын тайланг гаргуулан ажиллаж байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын http://burtgel.pfsp.gov.mn/ сайтанд 2021 оны жилийн эцсийн байдлаарх үндсэн хөрөнгийн бүртгэлийг шивж оруулсан.	
Албан шаардлага	Ахмадын сангийн санхүүгийн тайланг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэж, хөрөнгийн зарцуулалтыг бүртгэж, тайлагнаж байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.	Ахмадын сангийн санхүүгийн тайланг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны тайланд нэгтгэж, хөрөнгийн зарцуулалтыг бүртгэж, тайлагнахаар 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийг үлдэгдлээр тусгаад байна. Холбогдох баримтыг Үндэсний аудитын дүгнэлтийн биелэлтийн хэрэгжилтийг тайлагнадаг https://fas.audit.mn/ сайтанд байршуулж хариуцсан аудиторт хүргүүлсэн.	95
Албан шаардлага	Төсвийн хэмнэлтийн талаар гаргасан Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.	Том татвар төлөгчийн газар нь 2022 оны 04 сарын 29-нд гарсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж тус газрын 2022 оны урсгал санхүүжилт 2.1 тэрбум төгрөгөөс 1.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй бөгөөд 148.9 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.	95
Албан шаардлага	Харьяа Татварын албадаар хөрөнгө бэлтгүүлж, балансаас баланст шилжүүлэн бүртгэхгүй байх, төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.	Татварын ерөнхий газрын хөрөнгөд бүртгэлтэй 9.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 6 ширхэг хөрөнгийг ТӨБЗГ-ын 3-р сарын 07-ны өдрийн А-1/409 тоот албан бичиг, 283.4 сая төгрөгийн 580 ширхэг хөрөнгийг ТӨБЗГ-ийн 12-р сарын 14-ны өдрийн А-1/2429 тоот албан бичгийн дагуу Харьяа Татварын албадад балансаас балансад шилжүүлсэн бөгөөд, ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн хөрөнгө бэлтгүүлэх, балансаас баланст бүртгэх үйлдэл хийгээгүй, өмнөх зөрчлийг давтан гаргахгүй ажиллаж байна.	95
Зөвлөмж	Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын мөрдөж, шагнал урамшууллыг илүү олгохгүй байх;	Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, 80 дугаар зүйлийн 80.1, сангийн сайдын 2020 оны 168 дугаар тушаалаар баталсан “Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам”-ын 1.2, 2.1, 2.2, 2.3 дах заалтыг үндэслэн үр дүнгийн урамшуулалд 02-р сарын 09-ны А/19, 03-р сарын 09-ны А/32, 04-р сарын 07-ны А/42, А/43, 05-р сарын 10-ны А/48, 6-р сарын 09-ны А/63, 07-р сарын 06-ны А/78, А/79, 9-р сарын 08-ны А/100, 10 дугаар сарын 7-ны А/128, А/129, 11-р сарын 09-ны А/177, 12-р сарын 08-ны А/192, 12 дугаар сарын 19-ны А/200, А/201 тоот тушаалын дагуу нийт 368,9 сая төгрөгийг олгосон. Аудитын байгууллагын зөвлөмжийн дагуу хууль, журмаас гадуур шагнал, урамшуулал олгоогүй болно.	100
Зөвлөмж	Олон автомашинтай аймаг, нийслэлийн Татварын хэлтсүүдийн автомашиныг	ТЕГ-ын ӨХБЗөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 04-нд хуралдаж 13 татварын албаны 495.4 сая төгрөгийн анхны өртөгтэй 438.3 сая төгрөгийн хуримтлагдсан	100

	цэгцлэх арга хэмжээ авах, албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрхгүй албан тушаалтнууд автомашин ашиглаж байгаа асуудлыг таслан зогсоох;	элэгдэлтэй 13 ширхэг суудлын автомашиныг актлах, дуудлага худалдаанд оруулах шийдвэрийг 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 01/1094 дугаар албан тоотоор холбогдох материалын хамт ТӨБЗГ-т хүргүүлж 11-р сарын 08-ны өдрийн 498 тогтоолоор шийдвэрлүүлсэн. Татварын албаны хэмжээнд хэрэглэж байгаа 59 машиныг төрийн хэмнэлтийн хуулийн 6-р зүйлийн 6,1 дэх хэсэгт заасны дагуу албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглосон бөгөөд 6,3, 6,5-д заасны дагуу албан ажлын машин болгож өөрчлөн ТУБ-ын албан томилолт болон газар дээрх хяналт шалгалт хийхэд ашиглаж байна.	
Зөвлөмж	Аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулан дотоод хяналтыг хэрэгжүүлэн алдаа зөрчлийг арилгах, харьяа Татварын албадын нягтлан бодогчдыг хариуцлагажуулах, нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллах;	Татварын албадын нягтлан бодогчдод 6-р сард цахим сургалт явуулж, сургалтаар аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулан дотоод хяналтыг хэрэгжүүлэн алдаа зөрчлийг арилгах, хариуцлагажуулах талаар анхааруулаа. Татварын 32 албаны нягтлан бодогчдыг нэгдсэн арга зүйгээр тухай бүр ханган аудитын зөвлөмжийн хэрэгжилт, Аудитын хэрэгжилтийн тайланг хугацаанд нь хүргүүлэхэд хяналт тавьж ажилласан.	95
УАГ-н зөвлөмжийн дүн			97.5

Сангийн яамнаас ирүүлсэн зөвлөмжийн байдал:

Сангийн яамнаас 2022 оны 05 дүгээр сарын 30-ны өдрийн 01/3726 дугаар албан бичгээр ирүүлсэн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-ний тайланд дурдагдсан 14 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаа.

Төрөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл	Үнэлгээ
СЯ-ын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 1/3726 дугаар албан бичгээр ирүүлсэн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-ний зөвлөмж	Татварын ерөнхий газраас ирүүлсэн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон холбогдох бусад тайланд хийсэн ажил, хүрсэн үр дүнгийн талаар тодорхой тусгаагүй, зарим тайлан нь товч танилцуулга хэлбэртэй байгаа дүгнэлт хийж, цаашид тайлан боловсруулалтыг сайжруулах, хүрсэн үр дүнг товч, тодорхой, иж бүрэн тайлагнахад анхаарах,	Татварын ерөнхий газрын 2022 оны үйл ажиллагааг тайлагнахад Засгийн газрын 2020 оны 2017 дугаар тогтоолоор баталсан төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах нийтлэг, тусгай шаардлагын хүрээнд иж бүрэн, алдаагүй, бодитой, товч, тодорхой, үр дүнд тулгуурласан байх, 2000 тэмдэгтэд багтсан байх зэрэг шаардлагыг хангаж, хяналт тавьж ажиллаж байна.	100
	Дээд байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, хагас жил тутам Сангийн яаманд тайлагнаж ажиллах,	2022 онд Дээд газраас ирсэн 47 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэн цахим хэлбэрээр холбогдох нэгжид хүргүүлэн өмнөх он болон хугацаатай өгөгдсөн 76 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг гарган Сангийн яамны ТЗУГ-т хугацаанд нь ТЕГ-ын 03/1294, 03/2905 тоот албан бичгээр, цахимаар 2022.05.31, 2022.12.30 өдөр хүргүүлэн ажилласан.	100
	Татварын ерөнхий газарт хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, Сангийн сайдын 2010 оны 242 дугаар тушаалаар баталсан “Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын ЗЭЭЛ, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу төслийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Сангийн яаманд ирүүлж хэвших,	Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам 2021 оны 01-р сарын 11-ний өдөр 4 дүгээр тушаалаар баталсан. Энэ журмын дагуу холбогдох үйл ажиллагааны /төслийн/ тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж байна. Татварын албанд 2021 ба 2022 онд гадаадын зээл тусламжаар нийт 3 төсөл, 1 хөтөлбөр хэрэгжиж, хяналт шинжилгээ, үнэлгээгээр 2021 онд 90.0, 2022 онд 95.61 үнэлгээ авсан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг энэхүү тайлангийн 5 дугаар хавсралтаар хүргүүлэв.	100

Аудит, хяналт, шалгалтын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад онцгой анхаарч, 70%-ийн хэрэгжилттэй зөвлөмжийг төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж ажиллах:	Аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулан дотоод хяналтыг хэрэгжүүлэн алдаа зөрчлийг арилгах талаар 6-р сард Татварын албадын нягтлан бодогчдод цахим сургалт хийж харууцлагуулах, нэгдсэн арга зүйгээр тухай бүр ханган 32 албаны нягтлан бодогчдыг аудитын зөвлөмжийн хэрэгжилттэй тухайн Аудитын орон нутгийн нэгжид хугацаанд нь хүргүүлэхэд хяналт тавьж 100 хувь хэрэгжүүлж ажилласан.	95
Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээг төлөвлөн байгууллагын төлөвлөгөөнд тусган ажиллах.	ТЕГ-ын ажилтан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, Татварын албаны ажилтан албан хаагчийн 2022 оны сургалтын төлөвлөгөөг тус тус батлан хэрэгжилтийг тайлагнав. Байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд сургалт хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлон танхим болон зайн хэлбэрээр 15 сургалт, Зайн сургалт 6 сургалт болон Ажлын байрны дадлагуулах сургалт 1 нийт 22 сургалт зохион байгуулсан байна. Нийт 1702 албан хаагч давхардсан тоогоор 5129 албан хаагч сургалтад хамрагдсан. Мөн гадаад сургалтад нийт 17 албан хаагч цар тахлын дараах хилээ нээсэн улсуудад танхимын сургалтад хамрагдсан. 2.Татварын албаны хэмжээнд төрийн захиргааны Ахлах түшмэл-17, Дэс түшмэл-398 албан хаагчид зэрэг дэв ТЕГД-ын 2022.09.06-ны өдрийн А/97 дугаар тушаалаар олгов. Мөн ТЕГ-ын даргын 2022.01.24-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар ТЕГ-ын 45 албан хаагч, харьяа 7 татварын албаны дарга нарын цалинг шинэчлэн тогтоов. Тайлант хугацаанд албан хаагчдаас тусламж хүссэн өргөдөл ирүүлснийг судлан Даргын болон Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн эмчилгээний зардал хүссэн 13 албан хаагч, галд гэр нь шатсан 2 албан хаагчид нийт 55,3 сая төгрөгийн тусламж олгов.	95
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, зохих мэдээллийг тухай бүр тогтоосон хугацаанд нь байршуулж, олон нийтэд мэдээлж байх, татварын албадын мэдээлэл байршуулалтад хяналт тавьж ажиллах,	Шилэн дансны тайлан мэдээг сар бүр shilendans.gov.mn сайтад байршуулсан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар харьяа нэгжийн нягтлан бодогч нартай холбогдон зааварчилгаа өгч ажиллаж байна. ТЕГ-ын жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар жилийн төсөв, төлөвлөгөө хугацаанд 4983 мэдээ байршуулан ажиллаж байна.	95
Татварын ерөнхий газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, удааширсан арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлэх цаашид төлөвлөгөөт ажлыг хугацаандаа, үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах,	ТЕГ-ын 2022 оны төлөвлөгөөний саналыг тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс авч нэгтгэн, тус газрын Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газраас хяналт шинжилгээ хийж, дахин засварлан ТЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Сангийн яаманд хүргүүлсэн. Сангийн яамны холбогдох нэгжээс хянан, засварлуулж, батлагдсан. Хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 2021 онд хэрэгжилт удаашралтай 70 хувьтай 17 арга хэмжээ байсныг төлөвлөгөөнд тусган бүрэн хэрэгжүүлсэн. ХШҮ-ээр 50.0 үнэлэгдсэн 2 арга хэмжээ байна. Сайжруулалт хийн хэрэгжилтийг хангав. Үүнд: 1. Татварын өрөнд ТУНС-с алданги тооцно Хугацаандаа төлөгдөөгүй татварын өрд торгууль, алданги ногдуулах системийн нэвтрүүлэлтийг бодит орчинд ТУНС-тооцоолол цэсийн алдангийн жагсаалтаар тооцож төстийн ажиллагааг хэрэгжүүлж нэвтрүүлсэн. Гэвч ковидын дараах нөхцөл байдал, эдийн засгийн сэргэлтийн энэ үед татвар төлөгчдийн хугацаандаа төлөөгүй өрөнд хугацааны алданги тооцох нь татвар төлөгчдөд дарамт үүсгэх эрсдэл бий болсон тул түр хугацаар хойшлуулсан. Мөн МУ-ын ЗГ-ын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлийн 2-д заасны дагуу аялал жуулчлал, зочид буудлын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгч нарын татвар төлөх хугацааг хойшлуулахаар үүрэг болгосон нь бусад салбарын бизнес эрхлэгч нарын хугацаандаа төлөөгүй өрд алданги ногдуулан хураах нь татварын тэгш шудрага байх зарчим алдагдана гэж үзсэн.	95

	2. Татварын хууль тогтоомж даган мөрдөлтийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг оновчтой болгож эрсдэлийг үр дүнтэй удирдана Татвар төлөгчийн 2017-2021 оны тайлангийн үзүүлэлтүүдэд үндэслэн татвар төлөгчдийн 2021-2022 оны татвар ногдох орлогыг бодит эсэхийг тодорхойлох, хууль мөрдөлтөд үнэлгээ хийх зорилгоор "KNIME" платформд машин сургалтын аргаар загварчилсан. Загварын үр дүнгээр системээс өндөр эрсдэлтэй том сегментийн 196, дунд сегментийн 273, жижиг сегментийн 653, бичил сегментийн 655 татвар төлөгчийг хяналт шалгалтад хамруулахаар тодорхойлж, ТУНС-д төлөвлөгөө үүсгэсэн. Татвар төлөгчийн хууль тогтоомж мөрдөлтийн түвшинг тодорхойлохоор тайлангийн ирц, тайлан залруулга, төлөлт, зөв тайлагнал гэсэн үзүүлэлтүүдээр KNIME платформд загвар боловсруулж, татвар төлөгчийг хууль тогтоомж мөрдөлтийн түвшингөөр 4 ангилан ТУНС-д бүртгэсэн. Ингэснээр татвар төлөгч бүрийн татварын тайланг хоцроож илгээсэн хугацаа, давтамж, тайлан засварласан тоо, татварын өрийн насжилт, хугацаа хоцроож төлсөн татварын төрөл тус бүрээр системээс харах боломж бүрэн бүрдсэн. Татварын хяналт шалгалтын түүхэн өгөгдөлд үндэслэн татвар төлөгчийн сегмент, эдийн засгийн салбарын хувьд дундаж зөрчил, төлбөрийн дүнг интервалаар тодорхойлох загварыг KNIME платформд хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Уг загварыг 2021-2022 онд үйлдсэн татварын хяналт шалгалтын актад ажиллуулахад 83.3-94.3%-ийн магадлалтай эрсдэл тооцсон болохыг баталсан ба энэ нь татвар төлөгчийн эрсдэлийг үр дүнтэй удирдах боломжийг бүрэн бүрдүүлсэн.	
Байгууллагын ил тод байдлыг хангах ажлын хүрээнд “Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт”-ийн дагуу шаардлагатай мэдээллийг татварын байгууллагын цахим хуудсандаа бүрэн байрлуулан тухай бүр шинэчилж байх	ТЕГ-ын даргын 2022.12.-01-ний өдрийн "Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах тухай" А/187 дугаар тушаалаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нийтэд ил тод мэдээлэх мэдээллээс татварын албанд хамааралтай 38 төрлийн мэдээлэл болон түүнийг байгууллагын цахим хуудсанд байршуулж нийтлэх, тайлагнах, газар, хэлтсийн хуваарь, цаг хугацааны давтамж, мөн Опендата-д байршуулах мэдээллийн хуваарыг тус бүр баталж тушаалыг ЗББН-үүд мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байгаад хяналт тавин хагас, бүтэн жилээр ХШҮ хийн ажиллаж байна.	95
Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын хүрээнд иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудсанд байршуулах	ТЕГ-ын бүх албан хаагчдыг дотоод бүтцийн нэгжээр нь ангилан утас, өрөөний дугаар, цахим хаягын хамт цахим хуудсанны холбоо барих хэсэгт байршуулсан. Мөн ТEG-ын даргын А/80 дугаар тушаалаар баталсан “Угтах үйлчилгээний журам”-ын хэрэгжүүлж 1 давхрын угтах үйлчилгээний ажилтан иргэдийг өдөр бүр 8.30-17:30 цагт хүлээн авч уулзаж 18001288-р тусгай дугаар болон 1111-төвд өгсөн өргөдөл, гомдол, саналыг тухай бүрт нь шийдвэрлэж байна.	100
Төсвийн төлөвлөлтийг сайжруулах, урсгал зарлагын өр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах	Татварын албадад зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэг, чиглэл өгч хяналт тавин дараах ажлыг хийж гүйцэтгэв. 2023 оны төсвийн төлөвлөлтийг бодит үр дүн, норм, норматив, өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн төлөвлөв. 2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд зүй зохистой зарцуулж өр авлага шинээр үүсгэхгүй байхад анхаарч 2021 оны жилийн эцсийн өглөг 673,5 сая төгрөг байсанаас 2022 оны байдлаар 74,2 сая төгрөгийн өглөг болгож бууруулснаас Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн барилгын барьцаа 5,154,906, Баянхонгор аймгийн татварын хэлтсийн барилгын барьцаа 69,020,197 өглөгүүд байна.	95
Татварын тайлан хүлээн авалтын түвшинг нэмэгдүүлэх ялангуяа ААНОАТ 132525 байхаас 80992 буюу 65.3%, Суутган-1 татварын тайлан хүлээн авалт 199,871 байхаас 125,284 буюу 62.7%-ийн гүйцэтгэлтэй байгаад анхаарах	1.Зөвлөмжийн дагуу ТEG-ын даргын 2022 оны 01/1895 дугаар албан бичгээр татварын өр үлдэгдэлгүй, эрсдэлгүй 78.638 хуулийн этгээдийг татан буулгах саналыг Сангийн яаманд уламжлан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 03/7104 дугаар албан бичгээр Санхүүгийн тайлан 8 улирал өгөөгүй 58.632 хуулийн этгээдийг татан буулгах санал хүсэлтийг УБЕГ-т хүргүүлэн, 2022 оны 10 сарын 28-ны өдөр УБЕГ-ын цахим хуудсаар татан буулгах хуулийн этгээдийг зарлах арга хэмжээг хэрэгжүүлсэн.	95

	https://burtgel.gov.mn/post/61801f 2. ААНОАТ-ын 2022 оны 2-р улирлын тайлангийн ирц 139554 ирүүлэхээс 78189 ирүүлж 56.0 хувь, Суутган-1 тайлангийн ирц 2022.03-р улиралд 219391 тайлан ирүүлэхээс 138643 тайлан ирүүлж тайлангийн ирц 63.0 хувьтай байгаа нь 2022 оны төсвийн тухай хуулийн шалгууртай үзүүлэлттэй харьцуулсан үнэлгээгээр ААНОАТ-ын төрлөөр 70.00 хувь, Суутган-1 төрлөөр 78.75 хувь байгаа нь 2021 онтой харьцуулахад ААНОАТ-ын тайлангийн хувь 4.7, Суутган-1 тайлангийн ирцийн хувь 16.05 хувиар өссөн байна.	
Татварын тайлангаар болон хяналт, шалгалтын актаар ногдуулсан өмнөх онуудын татварын өрийг барагдуулах	Урьд оны өрийн барагдуулалт: Тайлангаар ногдуулсан өрийн 2,204.1 тэрбум төгрөг буюу 57.2 хувь, хяналт шалгалтын актаар ногдуулсан 83.6 тэрбум төгрөг буюу 10.4 хувийн барагдалттай байгаад дараах хүчин зүйлс нөлөөлсөн. Үүнд: 1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар “Шинэ сэргэлтийн бодлого – Аялал жуулчлал” сэдэвт хэлэлцүүлгийн үр дүн, аялал жуулчлалыг сэргээх, тэргүүлэх бодлогын асуудалтай танилцаж, Засгийн газрын холбогдох гишүүдэд ЗГХЭГ-ын 5052 тоот хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгсөн. Тус салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 1,398 татвар төлөгчөөс 985 татвар төлөгч 47.2 тэрбум төгрөгийн өртэй байгаагаас 7.9 тэрбум төгрөгийн өртэй 33 татвар төлөгчид өр хураах ажиллагаа хэрэгжүүлж арилжааны банкин дахь дансыг битүүмжилснийг цуцалж, дээрх салбарт албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байхыг чиглэл болгосон. 2. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй, татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсаар ногдуулсан 312.08 тэрбум төгрөгийн төлбөрийг эс зөвшөөрч маргаан таслах зөвлөлд хандсан шийдвэрлэгдээгүй өр баазад бүртгэлтэй. 3. Хүндрэлтэй өрийн ангилалд хамаарч буй дампуурсан, эзэн холбогдогч нас барсан, эрэн сурвалжлах тогтоолтой, нэмэгдсэн өртгийн албан татварын хий бичилттэй, Татварын ерөнхий газар, Нийслэлийн Татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөл, Шүүхээр хянагдаж буй эцсийн шийдвэр гараагүй, шүүхээр шийдвэрлүүлэхээр хүлээгдэж буй гэх зэрэг шалтгаантай 1,092 татвар төлөгчийн 858.12 тэрбум төгрөгийн өрийг татварын алба дангаараа барагдуулах боломжгүй, бусад байгууллагад хамтран ажиллах санал, албан бичгийг хүргүүлээд байна. 2022 онд цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийн үед өртэй татвар төлөгчдөд албадлагын бус үйлчилгээнд суурилсан татвар хураалтыг түлхүү хэрэгжүүлж ажилласантай мөн холбоотой байна.	90
Татварын ерөнхий газрын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, журамд тогтоосон хугацаанд Сангийн яаманд тайлагнах	Зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг ханган Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд холбогдох санал зөвлөмжийг бүрэн тусгах, шаардлагатай холбогдох баримтуудыг хавсралтаар бүрдүүлэн Сангийн сайдын 2018 оны 143 дугаар тушаалаар баталсан “Сангийн яамны харьяа агентлагийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-д заасан хугацаанд буюу 2023 оны 01 сарын 10-ны өдөр Татварын ерөнхий газрын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2023 оны 01 сарын 10-ны өдөр Сангийн яаманд хүргүүлэв.	100
Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ирүүлэхдээ Татварын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжээс үнэлгээ өгсөн үзүүлэлт тус бүрд тайлбар, дүгнэлт, цаашид сайжруулах санал, зөвлөмжийг тусгаж байх	Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн нийт ажилтнуудад сургалт явуулан Сангийн яамнаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хэрхэн хангах талаар анхаарах асуудлаар арга зүйн зөвлөгөө өгсөн. Тайлагналын агуулга, хэлбэрийг шаардсан түвшинд хүргэв.	100
СЯ-ны ХШҮ зөвлөмж дүн		96.79

Гүйцэтгэлийн хувь: 97.14

2.6 Шилэн дансны хөтлөлт

Хэрэгжилт: Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2 дугаар бүлэгт заасгы дагуу Татварын албаны хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 3 бүлэг 20 дэд цэсний 151 мэдээ тайлан илгээхээс 33 албаны хэмжээнд 4’983 мэдээ байршуулахаас 4’983 мэдээ буюу 100.00 хувь хугацаанд нь байршуулсан байна

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээ, тайлан илгээсэн байдлыг хугацааны хувьд татварын албадаар авч үзвэл:

Д/Д	Албаны нэр	Нийт мэдээлэх мэдээллийн тоо	Хугацаандаа мэдээлсэн мэдээллийн тоо	Хугацаа хоцроомж мэдээлсэн мэдээллийн тоо	Мэдээлэл байршуулаагүй	Хувь
1	ТЕГ	151	151	-	-	100.00
2	Архангай	151	151	-	-	100.00
3	Баян-өлгий	151	151	-	-	100.00
4	Баянхонгор	151	151	-	-	100.00
5	Булган	151	151	-	-	100.00
6	Говь-Алтай	151	151	-	-	100.00
7	Говьсүмбэр	151	151	-	-	100.00
8	Дорноговь	151	151	-	-	100.00
9	Дорнод	151	151	-	-	100.00
10	Дундговь	151	151	-	-	100.00
11	Завхан	151	151	-	-	100.00
12	Өвөрхангай	151	151	-	-	100.00
13	Өмнөговь	151	151	-	-	100.00
14	Сүхбаатар	151	151	-	-	100.00
15	Сэлэнгэ	151	151	-	-	100.00
16	Төв	151	151	-	-	100.00
17	Увс	151	151	-	-	100.00
18	Ховд	151	151	-	-	100.00
19	Хөвсгөл	151	151	-	-	100.00
20	Хэнтий	151	151	-	-	100.00
21	Дархан-Уул	151	151	-	-	100.00
22	Орхон	151	151	-	-	100.00
23	ТТТГ	151	151	-	-	100.00
24	Нийслэл	151	151	-	-	100.00
25	Хан-Уул	151	151	-	-	100.00
26	Баянзүрх	151	151	-	-	100.00
27	Сүхбаатар дүүрэг	151	151	-	-	100.00
28	Баянгол	151	151	-	-	100.00
29	Багануур	151	151	-	-	100.00
30	Багахангай	151	151	-	-	100.00
31	Налайх	151	151	-	-	100.00
32	Сонгинохайрхан	151	151	-	-	100.00
33	Чингэлтэй	151	151	-	-	100.00
Дүн		4’983	4’983	-	-	100.0

Гүйцэтгэлийн хувь: 100.00

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээний тайлан

Монгол Улсын “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 09 дүгээр хавсралт “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт”-ийг хангах зорилгоор төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх ажлын биелэлт, үнэлгээ дараах байдалтай байна.

Д/Д	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоо	Гүйцэтгэлийн	
			Хувь	Оноо
1	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	99.00	4.95
2	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	100.00	5.00

3	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх	14	98.46	4.92
4	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээ	1	100.00	5.00
5	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	7	100.00	5.00
Нийт дүн		38	99.49	4.97

Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 09 дүгээр хавсралт ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 38 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж ТЕГ хэрэгжүүлдэггүй 8 үзүүлэлтийг үнэлээгүй болно.
/Хавсралт-8-р хэрэгжилт хүргүүлэв./

Гүйцэтгэлийн хувь: 99.49

Дөрөв. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээг агентлагийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт болон хэрэглэгчийн үнэлгээний оноог нөлөөлүүлэн тооцсон.

Д/Д	Агентлагийн үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	Үнэлгээ	
		Хувь	Оноо
4.1	Агентлагийн үйл ажиллагааны шалгуур	91.63	27.49
4.2	Хэрэглэгчийн үнэлгээний тайлан	99.28	14.89
Үнэлгээний нийт оноо		95.46	42.38

4.1 Агентлагийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт

Д/Д	Агентлагийн үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	Үнэлгээ	
		Хувь	Оноо
1	Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт	108.82	29.53
2	Татвар төлөгчийн бүртгэлийн өсөлт, бууралт, татварын суурийг өргөжүүлсэн байдал	110.65	15.00
3	Татварын ногдол, төлөлтийн байдал	61.92	7.91
4	Татварын тайлан хүлээн авалтын түвшин	84.87	14.55
5	Татвар өр хураалтын түвшин	69.08	7.46
6	Татварын хяналт шалгалтын дүн	94.91	9.20
7	Татварын буцаан олголт	99.54	3.99
8	Зуун төгрөгийн татварын орлогод ногдох зардлын хэмжээ	100.0	4.00
Үнэлгээний нийт оноо			91.63

Үнэлгээ: 91.90

Дэлгэрэнгүйг (Хавсралт-9)

4.2 Хэрэглэгчийн үнэлгээ

Татвар төлөгчдийн зан төлөв, сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааг судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эм Эм Си Жи” ХХК-тай хийсэн гэрээний дагуу гүйцэтгүүлсэн бөгөөд 1932 онд АНУ-ын социологич Ренсис Лайкертын үндслэсэн “Лайкертын шкал-Likert scale” аргыг ашиглан татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлсон байна.

Судалгааны талаар товч танилцуулбал:

Зорилго

Татвар төлөгчдийн хувьд татварын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэг, зан төлөв, сэтгэл ханамжийн үнэлгээ, тулгамдаж буй асуудлуудын талаарх санаа бодлыг тодорхойлох хүрээнд татвар төлөгчдийн сегмент тус бүрээр:

- Татварын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэг,
- Татвар төлөгчдийн зан төлөв,
- Татварын байгууллагын үйлчилгээ дэх сэтгэл ханамжийн үнэлгээ,

○ Тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох замаар цаашид татварын байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад шаардлагатай мэдээллийн суурийг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Түүвэрлэлт, хамрах хүрээ:

Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны түүвэрлэлтийг хийхдээ Татварын ерөнхий газрын тоон мэдээлэлд үндэслэсэн болно. 2022 оны байдлаар улсын хэмжээнд татварын төрлийн давхардсан тоогоор 441,545 татвар төлөгч байна. Үүний 47.5%-ийг нь хувиараа бизнес эрхлэгч иргэд, 40.9%-ийг бичил сегмент, 11.6%-ийг жижиг сегментийн татвар төлөгчид бүрдүүлж байна.

Судалгааны түүвэрт нийт 2134 татвар төлөгч хамрагдсан бөгөөд энэ нь нийт эх олонлог болох 441.5 мянган татвар төлөгчийг 95%-тай төлөөлөх бөгөөд алдааны түвшин 2.0% буюу судалгааны үр дүн $\pm 2.0\%$ -иар хэлбэлзэж болно.

Зураг 1. Түүврийн тооцоолол

Determine Sample Size

Confidence Level: ☒ 95% ☐ 99%

Confidence Interval:

Population:

Sample size needed:

Судалгаанд хамрагдсан татвар төлөгчдийг харьяа татварын байгууллагаар задлан дараах хүснэгтэд харуулав. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан татвар төлөгчийн харьяа татварын алба, түүврийн хэмжээ, эзлэх хувь

Харьяа татварын алба	Түүврийн хэмжээ	Түүвэрт эзлэх хувь
9 дүүргийн татварын алба	645	30%
Архангай аймаг	130	6%
Баян-Өлгий аймаг	65	3%
Баянхонгор аймаг	100	5%
Булган аймаг	108	5%
Говь-Алтай аймаг	90	4%
Говьсүмбэр аймаг	60	3%
Дархан-Уул аймаг	45	2%
Дорноговь аймаг	60	3%
Дорнод аймаг	70	3%
Дундговь аймаг	44	2%
Завхан аймаг	30	1%
Орхон аймаг	50	2%
Өвөрхангай аймаг	33	2%
Өмнөговь аймаг	97	5%
Сүхбаатар аймаг	75	4%
Сэлэнгэ аймаг	61	3%
Төв аймаг	144	7%
Увс аймаг	35	2%
Ховд аймаг	44	2%
Хөвсгөл аймаг	111	5%
Хэнтий аймаг	37	2%
Нийт	2134	100%

Татвар төлөгчдийн боловсрол, сэтгэл ханамжийг тодорхойлох судалгаанд 41% нь жижиг сегментийн татвар төлөгчид, 35% нь бичил сегмент, 24% нь хувь хүн сегментийн татвар төлөгчид хамрагджээ.

Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг нийт 11 бүлгийн 84 үзүүлэлтийн дунджаар тодорхойлсон. Албаны хэмжээнд нийт татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшин **88.36%** байна.

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭГ 1-5 ОНООНЫ СИСТЕМЭЭР ҮНЭЛҮҮЛСЭН.

- 4.50-5.00 буюу 90%-100% байвал үйлчлүүлэгч маш сэтгэл ханамжтай бөгөөд энэ нь бодит нөхцөл байдал дээр тийм ч олон тохиолддоггүй **онолын түвшний ойлголт** юм.
- 3.50-4.49 буюу **70%-89%** байвал үйлчлүүлэгч сэтгэл ханамжтай бөгөөд энэ түвшинд байхад харьцангуй санаа зовох зүйл бага буюу боломжийн гэж үздэг.

Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дүгнэлт:

Татварын ерөнхий газарт ISO 9001:2015 ЧМТ-ны олон улсын стандарт нэвтрүүлсэнээр хэрэглэгчийн /сонирхогч талуудын/ хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, сэтгэл ханамжид нийцсэн үйлчилгээ үзүүлэх үйл явц сайжирсан байна.

БҮЛЭГ	Анхаарах асуудлууд
Бүртгэлийн үйлчилгээ	Шинээр бүртгүүлэх, Бүртгэлээс хасуулах, Бүртгэлдээ нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг үйлчилгээнүүдэд анхаарах Бүртгэлийн үйлчилгээг цахимаар авах талаарх мэдээллийг хүргэх, цахим системийн хэвийн ажиллагааг хангах
Нэг цэгийн үйлчилгээ	Нэг цэгийн үйлчилгээний ажилчдын ажилдаа хандах хандлага буюу татвар төлөгчдөд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чин сэтгэлээсээ хандах байдал Үйлчилгээний түргэн шуурхай байдал Татвар төлөгчдийг ялгаварлахгүй жигд харьцах /Бичил сегмент болон хувь хүн илүүтэй анхаарах/
ТУБ-дын харилцаа, мэдлэг, ур чадвар	ТУБ-дын асуудлыг шийдвэрлэх хурд ТУБ-дын мэдлэг, ур чадвар Татвар төлөгчидтэй найрсаг, хүндэтгэлтэй харилцах /Бичил сегмент болон хувь хүн илүүтэй анхаарах/
Татвар ногдуулалт, тайлагнах	Цахим татварын системийн ажиллах хурд, гацалтгүй хэвийн ажиллагаа Бичил сегмент хувь хүмүүс цахим системийн хэрэглээний талаар мэдээлэл өгч, дадал бий болгох Бичил сегментийн татвар төлөгч ААН-ийн эзэн болон хувь хүмүүс өөрсдөө татварын тайлангаа гаргах байдал илүү байгаа учир энэ сегментүүдэд уг үйлчилгээтэй холбоотой сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх
Татвар төлөлт	Татвар төлөх хугацаанд уян хатан хандах байдал Татвараа хугацаандаа төлж чадаагүй хүндэтгэх шалтгааныг ойлгох байдал Жижиг, бичил сегмент болон хувь хүмүүст цахим татварын системээр төлбөрийн нэхэмжлэхээ үүсгэх, татвар төлсөн баримтаа цахим системээс авах зэрэг үйлчилгээг таниулах
НӨАТ	Жижиг, бичил сегмент болон хувь хүмүүс НӨАТ-ын тухай хуулийн талаар мэдээлэл өгөх НӨАТ төлдөггүй газруудад /Томоохон хүнс, бараа, хувцас, барилгын материал, авто сэлбэгийн худалдааны төвүүд, орон нутгийн дэлгүүр, буудал, онлайн худалдаа, сугалаа, эмийн бөөний төв гэх мэт/ анхаарал хандуулах, НӨАТ төлөгчөөр бүртгэх
Татварын хяналт, шалгалт	Татвар төлөгчдийг оновчтой сонгож хяналт, шалгалт хийдэг байх /сонгосон шалтгааныг ойлгуулах, тайлбарлах/ Хяналт шалгалтын ТУБ-дын хуулийн дагуу мэдээлэл, материал шаарддаг байдал Хяналт шалгалтын ТУБ-дын ёс зүй /Авлига, дарамт, хууль бус шаардлага/ Хяналт шалгалтаар тавигдсан дүгнэлт, актын үндэслэлтэй байдал, хяналт шалгалтын дараах зөвлөгөө /Том, дунд сегмент/
Татвар төлөгчдөд зориулсан сургалт	Сургалт зарлаж буй хугацааны тохиромжтой байдал Сургалтын тоог нэмэгдүүлэх, цахим сургалтыг нэмэгдүүлэх Сургалт орж буй ТУБ-дын мэдлэг чадвар, сургалтын үр өгөөжтэй байдал /Том, Дунд/
Лавлах утас 1800-1288	Утсаа түргэн шуурхай авах, хариу өгөх байдал /авч амжаагүй бол эргэж холбогдох/ ТУБ-дын асуудал шийдвэрлэх хурд Дуудлагыг бусдад дамжуулахгүй байх зэрэгт анхаарах
Албан ёсны сайтууд болон сошиал хаяг	Мэдээллээ шинэчлэх давтамж Татварын хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлт шинэчлэлтэй холбоотой, шинэлэг мэдээлэл оруулах байдал

	Сошиалаар мэдээллийг дамжуулахдаа сонирхолтой видео контент, бичлэг хэлбэрээр бэлтгэж, ойлгомжтойгоор оруулах
Татварын байгууллагын цахим шинэчлэл	Татварын байгууллагын цахим шилжилтэд татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ хамгийн өндөр байна. Цаашид шинээр бий болгосон цахим үйлчилгээнүүдийн хэрэглээг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээний давуу талуудыг татвар төлөгчдөд ойлгуулахад анхаарах

Дэлгэрэнгүйг (Хавсралт-10)**Зөвлөмж**

1. Татвар төлөгчдыг бухимдуулж буй оновчтой асуудлуудаа тодорхойлох
2. Тухайн асуудлыг үүсгэж буй гол шалтгааныг олж илрүүлэх ажлыг зохион байгуулах
3. Татвар төлөгчдийн сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж буюу асуудлыг сайжруулах шийдлүүдийг боловсруулах
4. Татварын улсын байцаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх ажлыг тасралтгүй, системтэйгээр зохион байгуулж үр дүнг тогтмол хэмжих
5. Чанарын мониторинг хийх
6. Давтан сургалт хийх
7. Татварын ерөнхий газарт нэвтрүүлсэн ISO 9001:2015 ЧМТ-ын олон улсын стандартын сайжруулалтын үйл явцад үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, хэрэглэгчийн үнэлгээний хэмжилтийг жилд 2-с доошгүй удаа дотоодыг болон хөндлөнгийн нөөцөөр хийж гүйцэтгэн сайжруулалтын алхмуудыг тодорхой төлөвлөж ажиллах

Үнэлгээ:

“Лайкертын шкал-Likert scale” аргыг ашиглан татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлсон үнэлгээг хяналт-шинжилгээ, үнэлгээний 100 онооны системд шилжүүлэхэд **99.28** байна.

-ooOoo-